

**ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2024 оны 12 дугаар сарын 05-ны өдөр, Пүрэв гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл: 1-2

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл: 3-10

1. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2024.12.04-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/ 3-10

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы
Төсвийн байнгын хорооны 12 дугаар сарын 05-ны өдөр
/Пүрэв гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Төсвийн байнгын хорооны дарга Ц.Даваасүрэн ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 25 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 52.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 12 цаг 52 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Томилолттой: Н.Алтанхуяг;
Чөлөөтэй: Т.Аубакир, Х.Булгантуяа, Ж.Ганбаатар, Х.Ганхуяг,
П.Мөнхтулга, Г.Тэмүүлэн;
Эмнэлгийн чөлөөтэй: Б.Заяабал, Б.Чойжилсүрэн.

Улсын Их Хурлын гишүүн, Боловсролын сайд П.Наранбаяр, Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг нар хуралдаанд оролцов.

Нэг.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2024.12.04-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Л.Гантөмөр, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, мөн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, Хөрөнгө оруулалтын бодлогын газрын дарга Б.Анар, Төсвийн хүрээний төлөвлөлтийн хэлтсийн дарга О.Мягмардорж нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Ё.Энхсайхан, мөн газрын Байнгын хороодын ажлын албаны Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, референт Б.Мөнгөн-Аргамж нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Л.Гантөмөр танилцуулав.

Илтгэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн З.Мэндсайхан, П.Сайнзориг нарын тавьсан асуултад Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Л.Гантөмөр хариулж, тайлбар хийв.

Байнгын хорооны дарга Ц.Даваасүрэн үг хэлэв.

Ц.Даваасүрэн: Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанд оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Татгалзсан: 5
Бүгд: 16
68.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Б.Мөнхсоёлын санал хураалтын дүнг дэмжсэнээр хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлэх санал гаргаж, дэмжсэнээр тооцов.

Нийт 16 гишүүнээс 12 гишүүн дэмжиж, 75.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдинням Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 13 цаг 16 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 24 минут үргэлжилж, 25 гишүүнээс 16 гишүүн хүрэлцэн ирж, 64.0 хувийн ирцтэйгээр 13 цаг 16 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ТӨСВИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Ц.ДАВААСҮРЭН

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

П.ОЮУНГЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 12 дугаар сарын 05-ны өдөр,
Пүрэв гараг
Төрийн ордон “Их эзэн Чингис хаан” танхим
12 цаг 52 минут.

ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Ц.Даваасүрэн: Эрхэм гишүүдийн энэ өдрийн амгаланг эрье.

Байнгын хорооны гишүүдийн хуралдааны ирцийг би та бүхэнд танилцуулъя.

Далайн Батбаяр гишүүн, Дамбын Батлут гишүүн, Хөххүүгийн Болормаа гишүүн, Цэрэнпилийн Даваасүрэн гишүүн, Даваагийн Цогтбаатар гишүүн, Ренчиндоржийн Батболд гишүүн, Батмөнхийн Батцэцэг гишүүн, Гомбын Ганбаатар гишүүн, Гонгорын Дамдинням гишүүн, Жигжидийн Батжаргал гишүүн, Жадамбаагийн Баясгалан гишүүн, Пүрэвжавын Ганзориг гишүүн, Баатаржавын Мөнхсоёл гишүүн нар оролцож байна.

Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж, Байнгын хорооны ирц 52 хувьтай байгаа учраас 2024 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье. Нөгөө алх нь хаачив. Мэдэгдье.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлэх асуудлыг та бүхэнд танилцуулъя.

1 асуудал байна.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 26, 27 оны төсвийн төслийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх асуудал байна.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулаад саналтай гишүүн байна уу? Алга байна.

Ингээд хэлэлцэх асуудалдаа оръё.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026, 27 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэж эхэлье.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг би та бүхэнд, ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг оруулъя.

Лувсанн्याмын Гантөмөр гишүүн, Монгол Улсын Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засгийн хөгжлийн сайд, Идэшийн Батхүү Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Лхагвабаярын Энх-Амгалан Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга, Бат-Ирээдүйн Анар Эдийн засаг, хөгжлийн яамны Хөрөнгө оруулалтын бодлогын газрын дарга,

Отгондэмбэрэлийн Мягмардорж Эдийн засаг, хөгжлийн яамны Төсвийн хүрээний төлөвлөлтийн хэлтсийн дарга гэсэн ийм бүрэлдэхүүн оролцож байна.

Хууль санаачлагчаас асуух асуулттай биш.

Эхлээд Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл 2026, 2027 оны төсвийн хүрээний төслийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх танилцуулгыг Эдийн засаг, хөгжлийн сайд Лувсаннъямын Гантөмөр танилцуулна. Гантөмөр сайд.

Л.Гантөмөр: Эрхэм гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая. Монгол Улсын Ерөнхийлөгч төсвийг үр ашигтай, хэмнэлттэй, алдагдалгүй батлах нь зүйтэй гэж үзээд Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд бүхэлд нь хориг тавьж, Улсын Их Хурал уг хоригийг хүлээн авч, хуулийг хүчингүй болгосон.

Төсвийг алдагдалгүй батлах хүрээнд төсвийн зарлагыг 2,3 их наяд төгрөг буюу дотоодын нийт бүтээгдэхүүний 2,4 хувьтай тэнцэх дүнгээр бууруулах, төсвийн зарлагыг бууруулсантай холбогдуулан төсвийн орлогыг 395 тэрбум төгрөг буюу дотоодын нийт бүтээгдэхүүний 0,4 хувьтай /Батбаяр гишүүн ээ, би юм уншиж байна шүү/, 0,4 хувьтай тэнцэх дүнгээр бууруулах, /Наранбаяр аа/ шаардлага үүссэн.

Иймд Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулан та бүхэнд танилцуулж байна.

Хуулийн төсөлд нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийг 2025-2027 онд алдагдалгүй байхаар, нэгдсэн төсвийн суурь тэнцлийг 2025 онд дотоодын нийт бүтээгдэхүүний 3,5 хувьтай тэнцэх хэмжээний ашигтай, 2026-2027 онд дотоодын нийт бүтээгдэхүүний 2 хувьтай тэнцэх хэмжээний ашигтай байхаар тооцож тусгалаа.

Инфляц 2023 оны эцэст 7,9 хувь байсан бол энэ оны 10 дугаар сарын байдлаар 7 хувьтай байна. Бид төсвийн хүрээний мэдэгдэлд 2025 оны жилийн дундаж инфляцыг 7,5 хувь гэж тооцож байсан бол төсвийн зарлагыг 2,3 их наяд төгрөгөөр бууруулж байгаатай уялдуулаад, 2025 оны дундаж инфляцыг өмнөх оны төсөөллөөс 0,3 нэгж хувиар бууруулж, 7,2 хувь байхаар хуулийн төсөлд тусгасан.

Төсвийн зардал буурснаар эрэлтээс үүдэлтэй инфляц өсөх дарамт нь буураад, мөнгөний бодлогын орон зай нэмэгдэхээр байгаа хэдий ч геополитикийн тогтворгүй байдал, уур амьсгалын өөрчлөлт, тээвэр ложистикийн саатлаас үүдэн импортын инфляц нэмэгдэх эрсдэлүүд хэвээр байгааг энд тэмдэглэн хэлье.

Улсын Их Хурлаас баталсан улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд 2025 оны эдийн засгийн өсөлтийг 8 хувьд хүргэх зорилт тавьсан учир төсвийн хүрээний мэдэгдэл дэх дотоодын нийт бүтээгдэхүүний төсөөллийг өөрчлөхгүй хэвээр нь хадгалсан.

Төсвийн зардлыг бууруулж байгаа нь зарим салбаруудын өсөлтийг хязгаарлах хэдий ч бид дараах хүчин зүйлийн нөлөөгөөр улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгасан 8 хувийн эдийн засгийн өсөлтийг хангах боломжтой гэж

үзэж байгаа. Энэ онд үйлдвэрлэлийн зориулалттай машин, тоног төхөөрөмж, ачаа, тээврийн хэрэгслийн импорт өмнөх оноос 34 хувиар өсөж, 2,9 тэрбум ам.доллар буюу нэрлэсэн дотоодын нийт бүтээгдэхүүний 15 орчим хувьд хүрсэн нь цаашдын эдийн засгийн потенциал, хүчин чадлыг нэмэгдүүлэхээр байна.

Экспортын хувьд энэ онд 78 сая тонн нүүрс экспортлохоор төлөвлөсөн бөгөөд 2024 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн байдлаар нүүрсний экспорт 78 сая тоннд хүрсэн байна. Цаашид экспорт энэ хурдаар он дуустал үргэлжлэхэд нүүрсний экспорт 2024 онд 83-84 сая тоннд хүрч, төлөвлөгөөнөөс 6-7 хувиар давахаар байна. Ирэх 2025 онд бид 83 сая тонн нүүрс экспортлох зорилт тавьсан бөгөөд төлөвлөгөөг мөн давуулан биелүүлэх бүрэн боломжтой гэж үзэж байгаа.

Мөн зэсийн баяжмалын экспорт өнөөдрийн байдлаар өмнөх оны мөн үеэс 9 хувиар өндөр байна. Уул уурхайн салбар энэ оны эхний 3 улирлын байдлаар 11,4 хувиар өсөөд байгаа нь энэ онд уул уурхайн салбарт ашиглагддаг хүнд машин механизмуудын импорт өмнөх оноос 2 дахин, ачааны тээврийн хэрэгсэл 85 хувиар тус тус өссөн зэрэг нөлөөгөөр 2025 онд уул уурхай болон тээврийн салбарын өсөлт өндөр байхаар байгаа юм.

Худалдаа, үйлчилгээний салбар 2024 оны эхний 3 улиралд 8,8 хувиар өслөө. Тус салбарт үйл ажиллагаа эрхэлж байгаа ААН-ийн тоо 6,2 хувиар, хөдөлмөр эрхлэлт 13 хувиар, зээл олголт 47 хувиар тус тус өссөн нь ирэх онд үйлчилгээний салбарын өсөлт тогтвортой хадгалагдах нөхцөлийг бүрдүүлж байна.

Эрчим хүчний салбар энэ оны эхний 3 улиралд 5,2 хувийн өсөлттэй байлаа. Тус салбарт хэрэгжиж байгаа Бөөрөлжүүт, Чойбалсангийн станц, Багануурын батарей хуримтлуурын бүтээн байгуулалтууд нийт эдийн засгийн потенциал хүчин чадлын суурийг нэмэгдүүлнэ гэж тооцож байна. Мөн эрчим хүчний либералчлалыг цогцоор нь алгуурлалгүй хэрэгжүүлснээр тус салбар дахь хөрөнгө оруулалт нэмэгдэх үндэс болох юм.

Хөдөө аж ахуйн салбар байгаль, цаг уурын нөлөөгөөр 2023 онд 8,9 хувиар, 2024 оны эхний 3 улиралд 25 хувиар дараалан унасан бөгөөд тус салбар 25 оноос сэргэж эхлэх төлөвтэй байгаа. Өөрөөр хэлбэл 2023 болон 2024 онд эдийн засгийн өсөлтийг доош нь татаж байсан хөдөө аж ахуйн салбар ирэх оноос эдийн засгийн өсөлтийг дэмжиж эхэлнэ гэж тооцож байна. Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн зориулалттай тоног төхөөрөмжийг гаалийн татвараас хөнгөлсний үр дүнд хүнсний үйлдвэрлэлийн зориулалттай тоног төхөөрөмжийн импорт энэ онд 56 хувиар нэмэгдсэн. Тоног төхөөрөмжийн импортын өсөлт болон хөдөө аж ахуйн салбарын сэргэлт нь цаашид боловсруулах салбарын өсөлтийг дэмжихээр харагдаж байгаа юм.

Эдийн засгийн бодит салбарууд дээр бий болж байгаа дээрх боломжуудыг 2025 онд бүрэн ашиглаж, эдийн засгийн өсөлтийг улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгасан 8 хувьд хүргэх зорилтыг хангах бүрэн боломжтой гэж үзэж байгааг энд дахин тэмдэглэн хэлмээр байна.

Эрхэм гишүүд ээ, та бүхэнд танилцуулж байгаа Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 26-27 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нь Төсвийн тогтвортой

байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагуудыг бүрэн хангасан болно. Хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсэж байна. Баярлалаа.

Ц.Даваасүрэн: Баярлалаа.

Танилцуулгатай холбогдуулаад хууль санаачлагчаас асуух асуулттай гишүүн байна уу? Мэндсайхан гишүүнээр тасаллаа. Мэндсайхан гишүүн асуултаа асууя.

3.Мэндсайхан: Гантөмөр сайдын танилцуулсантай холбоотойгоор өмнөх нөгөө хүчингүй болсон төсвийн төсөл дээр 1 асуудал сүүлд орж ирээд, санал хураагдаад яваад байсан нөгөө шүүхийн тухай хуулиараа шүүхийн хөрөнгө оруулалтын асуудлыг Сангийн яам хасаж болохгүй, Засгийн газар гэдэг нэг асуудал яригдаад, тэгээд нэлээн их хөрөнгө оруулалт нь танагдаад үлдчихсэн. Тэгээд сүүлд 2 дугаар хэлэлцүүлгийн үед, 2 дугаар хэлэлцүүлгийн үед энэ асуудал яригдаад байсан. Энэ маань сая энэ шинэ төсөл дээр бүрэн сууж орж ирж, тэр шүүхийн үйл ажиллагаагаа явуулах, хараат бус байдлыг нь хангахад Засгийн газар хөрөнгө оруулалтын асуудлыг нь бүрэн тусгаж өгсөн үү гэдэг асуулт байна.

2 дугаарт, Гантөмөр сайдыг байгаа дээр нэг юм асуух гээд. Энэ төсөвтэй холбоогүй. Евро Азийн эдийн засгийн холбоотой нөгөө ОХУ-тай бид нар нэг ярьж байгаад тариф болон харилцан бууруулах асуудал яригдаад байгаа гэж сонссон. Тэгээд энэтэй холбоотойгоор нөгөө бид нар яах вэ, манайх ОХУ болон энэ Эстоны орнууд руу хөнгөлөлттэй, татварын хөнгөлөлттэй нөхцөлөөр хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн гаргая гэж. Тийм ээ. Эргүүлээд бид нар яг ийм нөхцөлтэй ороод ирэхээр тэгээд дотооддоо жоохон өндийж байгаа салбараа татаад унагаачих тийм эрсдэл үүсчих вий дээ. Зүгээр, миний сонссоноор Засгийн газар дээр иймэрхүү, энэ асуудлыг яриад дэмжчихсэн гэж би ойлгосон. Тэгэхээр яг ижил төстэй мах, гурил ч гэдэг юм уу, импортын бүтээгдэхүүн дээр тарифын ямар нэгэн хөшүүрэггүй, хязгаарлалтгүй болчих юм бол манай дотоодын үйлдвэрлэгчдийг цохиод унагаачих ийм нөхцөл байдал үүсэх вий дээ. Энэ дээр ямар байгаа юм бол оо гэдэг энэ тайлбарыг сонсьё гэж бодож байна.

Ц.Даваасүрэн: Гантөмөр гишүүн хариулъя, сайд.

Л.Гантөмөр: Тэгэхээр төсвийн хуулийн төсөл хэлэлцэх үеэр Мэндсайхан гишүүний ярьж байгаа хөрөнгө оруулалтууд хэрхэн нэмэгдсэн, хэрхэн хасагдсан тухай яригдана. Тэгээд хэдүүлээ одоо бол яг дэгийнхээ хүрээнд төсвийн хүрээний мэдэгдлээ ярих нь зөв байх.

Евро Азийн худалдааны хэлэлцээр бол түр хэлэлцээр. Энэ эхлээд 2 дахь жилийнхээ нүүрийг үзэж байгаа. 2 жилийнхээ дотор батална гэдэг энэ түр хэлэлцээрийн жанжин шугамыг бол 2 жилийн өмнө тохирсон, тогтсон. Тэгээд энэ хүрээнд яриа хэлэлцээр явж байгаа. Монголын талаас тавьж байгаа санал бол өндөг болоод улаан буудай гэдэг зүйлсийг бид нар татвартай байлгана гэдэг саналыг тавьж байгаа. Нөгөө тал бол ийм байна гээд саналаа тавьж байгаа. Энэ бол хэлэлцээр. Хэлэлцээрийн эцсийн дүгнэлт бол удахгүй гарна. Байнгын хороодоор хэлэлцүүлэгдэнэ. Тэгээд энэ процесс яаж явав, аль тал нь ямар саналтай байна вэ, эдийн засгийн хувьд аль нь өгөөжтэй байна вэ гэдэг зүйлийг ярих байх.

Ер нь бид нар бол 2 жилийн өмнө юу ярьсан бэ гэхээр бид энэ Евроазийн бүсэд, ялангуяа ОХУ-д бараг эдийн засгийн хоригтой байна. Тэгээд манай бараа бүтээгдэхүүн бол асар өндөр татвартайгаар нэвтэрч байна. Тийм учраас энэ хоригоос гарах хэрэгтэй гэдэг зүйлийг тухайн үеийн Эдийн засаг, хөгжлийн сайд бол хэлж байсан байна. Яг энэ хүрээндээ Оросын тал бол бид тэгвэл харилцан ашигтай байх тэр хувилбар луу алхъя гэж. Монгол Улсын хувьд бол 6 хувь гээд маш тодорхой татварын хэмжээтэй. Гэтэл нөгөө тал маань бол дээд талын бүтээгдэхүүний татварын хэмжээ 50 хувьд хүрдэг. Нэг үгээр хэлбэл Монголын авч байгаа татвараас нөгөө талын авч байгаа татварын хэмжээ 8, 9 дахин өндөр байна гэсэн үг. Тэгэхээр тэнцвэртэй байдлыг хангахын төлөөх хэлэлцээрүүд явж байгаа гэдгийг та бүхэнд хэлье. Баярлалаа.

Ц.Даваасүрэн: Сайнзориг гишүүн асуулт асууя. Түрүүн гар өргөсөн байна лээ.

П.Сайнзориг: Баярлалаа. Би 1 хоёрхон асуулт байна. Ингээд Төсвийн хүрээний мэдэгдэл, ингээд залгуулаад бид нар төсвөө ингээд яриад, хэлэлцээд батлахаас өөр гарцгүй. Тэгэхдээ миний нэг санаа зовж байгаа юм нь бид хэд энэ ерөнхийдөө ирэх жилүүдэд нийт төсвийн маань 70 хувийг урсгал зардал, тэр дундаа зөвхөн тэтгэвэр, хүүхдийн мөнгө, цалин хөлс эзлээд цаашдаа энэ эдийн засгийн тэлэлтийг тогтвортой авч явах дэд бүтцийн юмнаасаа бид нар ингээд юу гэдэг юм бэ дээ, бас л хөнгөн л хандлаа л даа. Тэгээд ийм нөхцөл байдал руу ингээд орчихлоо. Тэгээд би энэ дээрээс яах вэ, зүгээр зарим эхлүүлчихсэн боловч үйл ажиллагаа нь явж байгаа энэ гадаадын зээл тусламжаар хэрэгжиж байгаа энэ зарим төслүүдийн яг хугацаандаа ашиглалтад орох асуудал дээр энэ цаашдаа яах вэ гэдэг дээр Эдийн засгийн хөгжлийн яам ямар тооцоо хийсэн бэ? Жишээ нь Нефть боловсруулах үйлдвэр. Цэвэрлэх байгууламж. Өнөөдөр л гэхэд бид нар ингээд төсвийн мэдээлэл аваад байж байхад гадаадын зээл тусламжаа, ашиглалтаа ингээд багасгачхаж байна шүү дээ. Энэ төсвийнхөө зарчимд нийцүүлээд. Мөнгө нь байгаад байдаг нефтийн үйлдвэрийг олон жил яриад сүүлдээ иргэд маань ингээд итгэхээ болилоо. Ингээд худлаа яриад хэдэн жил ярьдаг юм гээд. Жил ирэх тусам л инфляц, бараа материалын үнийн өсөөд ажиллах хүчний зардал гээд заримдаа бүр санаа зовох юм. Тэгээд бид хэд нөгөө зарим гишүүдийн ингээд попролт нь энд эндээд ийм л нөхцөл байдал руу оруулчихлаа л даа. Одоо тэгээд. Тэгээд би энэ зүйлүүд ингээд хугацаа хойшилж явах уу, үгүй юү.

2 дугаарт, яах вэ, энэ хөрөнгө оруулалтын юмнууд нэлээн багасаж байгаатай холбоотой хувийн хэвшилтэйгээ л бид хэд нэлээн томоохон орон зайн дээр ярина гээд байдаг. Хувийн хэвшилтэй ярих орон зайг ярих механизм болж байгаа Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хуулийг 1 ч төслийг хөдөлгөж чадаагүй байгаа, баталснаас хойш 1 ч шүү. Энэ Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хуулиар би нийслэлийн хэмжээнд л зүгээр ярья. Нэг тоглоомын талбайг бариулахад жилийн хөгжлийн төлөвлөгөөнд Улсын Их Хурлаар оруулчихсан байхыг шаарддаг байхгүй юу. Бүтэшгүй. Жилийн хөгжлийн төлөвлөгөөнд оруулахын тулд бараг 2 жил явж байж орно. Тэгээд ямар ч ийм ажиллагаагүй нэг ийм хууль хийчхээд, төр, хувийн хэвшил нь түншлэл л гээд байдаг. Хувийн хэвшилд орон зай гаргаж өгнө өө гээд байдаг. Тэгээд хувийн хэвшлийн тэлэх орон зайгаа бүрдүүлэх тэр дэд бүтцийн юмнаас нь бид хэд харамлалчихлаа. Дэд бүтцийг нь бүрдүүлж өгсөнгүй. Цэвэрлэх байгууламж орохгүй бол энэ нийслэлийн энэ төвлөрөл саарахгүй, энэ орчны бохирдол буурахгүй, орон сууцжуулах буудал зогсоно. Энэ утаа хэвээрээ

байна. Нефтийн энэ үйлдвэрээ барьж чадахгүй бол гадаад валют, гадаад худалдааны тэнцэл дээр бид хэд угаасаа валют урсгасан хэвээрээ л байна. Тэгээд хохирогч нь хэн юм бэ? Ийм л нөхцөл байдлууд байна. Тэгээд би ер нь яах вэ, зүгээр томоохон төслүүдээс энэ зээлийн ашиглалттай холбоотой төсвийн хүрээний мэдэгдэл дээр энэ бодлоготойгоо уялдуулахад энэ 2 төсөл чинь хэр явах юм бэ, дуусах юм уу? Зоригтой, хурдтай Засгийн газар гэж бид хэд ярьсан. Одоо тэгээд яадаг юм бол доо. Одоо.

2 дугаарт, энэ Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хуулийг өөрчлөх бодол байна уу. Тэгээд энэ чинь ерөөсөө 1 ч төсөл хөдөлгөөгүй байж байхад нэг их сайхан хууль хийчихсэн юм шиг үүнийгээ ингээд л хамгаалаад л байгаад байдаг байхгүй юу. Яах вэ, үүнтэй би зүгээр уялдуулж л асууж байгаа юм.

Ц.Даваасүрэн: Гантөмөр сайд хариулъя. Эдийн засгийн өрсөлдөөнтэй холбоотой

Л.Гантөмөр: Сайнзориг гишүүний асуултад хариулъя. Бид нар бол парламентын засаглалтай улс. Парламент бол Монгол Улсын хөгжлийн бодлогыг гаргах эрхээ хэнтэй ч хуваалцахгүй. Парламент сая бидний өргөн барьсан төсөв дээр ямар дүгнэлт гаргасан бэ гэвэл та нар алдагдалгүй батал гэдэг дүгнэлтийг та бүхэн гаргасан. Бид нар хамт сууж байгаад гаргасан. Гаргасан дүгнэлтээсээ бид нар их амархан ухарч ерөөсөө болохгүй. Зардал бууруул гэсэн, алдагдалгүй болго гэсэн. Яг энэ чиглэлээр Засгийн газар боловсруулж байгаа. Засгийн газар парламентыг чирдэг тохиолдол ерөөсөө байгаагүй. Монгол парламентын засаглалд шилжсэнээс хойш. Парламент өөрөө Засгийн газрыг удирддаг. Тэр удирдлагаа хэзээ ч алдаж байгаагүй. Энэ удаа ч гэсэн удирдсан. Удирдсан учраас Ерөнхийлөгч хориг тавьсан.

Тэгэхээр бол парламент өөрөө бодлогоо л ярих хэрэгтэй. Тийм учраас парламент өөрөө бодлогоо яриад төсвөө батлах эрх нь та бүхэнд байгаа байгаа. Бид бол алдагдалгүй батална гэдэг ийм л зарчмыг тавьж байгаа. Асуудал байгаа бүгдээрээ мэдэж байгаа. Мэдэхгүй царайлаад популизм хийж байгаа. Популизм хийгээд популизм өөрөө ямар өртөгтэйг бүгдээрээ мэдэрнэ. Өмнөх популистууд өнөөдөр юу болгож байгааг бүгдээрээ харж байгаа. Одоо энэ их сайхан уран ярьсан хүмүүсийн популизм бас адилхан, яг таны хэлдэг нефтийн үйлдвэрийг хойшоо татна. Баталгаатай. Арын хаалга гэж байхгүй. Хөдөө аж ахуйн салбарт хэрэгжих гэж байсан төслүүдийг хойшоо татна. Баталгаатай. Тийм учраас бол юу хэн хойшоо татсан гэдэг бол энэ хар дээр цагаанаар түүх болоод үлдэх юм. Зүгээр парламент нэгдсэн бодлогыг хэлэлцүүлгээр гаргаж, олонх нь асуудлаа хамгаалдаг тийм тэнхээ удахгүй сууна гэдэгт бол би эргэлзэхгүй байгаа, эргэлзэхгүй байгаа. Тийм учраас бол хэдүүлээ хийгээд явна.

Нөгөө талдаа Сайнзориг гишүүний хэлж байгаа түмэн зөв. Түншлэлийн хуулийг бол асар хүндрүүлж гаргасан юм байна лээ. Ер нь бол түншлэл битгий хий гэдэг хууль юм байна лээ. Тийм учраас энэ түншлэлийн хуулиа та бүхэн яаралтай хараач ээ, санал, дүгнэлт өгөөч ээ. Намайг удирдаад, би Эдийн засгийн яамыг удирдахаас илүү парламент өөрөө энэ дээр ажил хэрэгч хандаж өгөөч гэж хүсмээр байгаа юм. Хүсмээр байгаа юм. Үнэхээр хувийн хэвшил гаднын хөрөнгө оруулагчид тодорхой дэд бүтцийн салбарт хөрөнгө оруулалт хийх тэр боломжийг бид нар гаргаж өгөхгүйгээр цаашаа энэ улс орон явахгүй гэдэг бол их тодорхой байгаа.

З дахь зүйл бол үнэхээр баталсан хууль болгоны ард төсвийн урсгал зардал нэмсэн байна лээ шүү. Би бол өмнөх Засгийн газрууд нэг аймаар өөрсдөө сайн дураараа зардал нэмсэн байна гэж ерөөсөө харахгүй байгаа. Парламент өөрөө баталсан. Малчны тэтгэврийг парламент баталсан. Киноны хуулийг парламент баталсан. Соёлын ... /минут дуусав/

Ц.Даваасүрэн: Тэр юуг нь нэмээд хэлчихье. Нөгөө нэг төр, хувийн хэвшлийн хуулийн хэрэгжилтийг асуугаад байсан юм. Гантөмөр сайдын микрофоныг өгчихье.

Л.Гантөмөр: Тийм байгаа юм. Улс төрийн мэдэгдэл биш шүү. Тийм, тийм. Ер нь бол төсвийн хүрээ өөрчлөгдсөн шалтгаанаа бас би хэлж байна л даа. Тэгэхээр бол, тэгэхээр та бүхэн маань юмандаа жоохон анхаараарай л гэж хүсмээр байгаа юм. 1, 2 өдрийн попрол, тодролт бол өөрөө хэр зэрэг төлбөртэй вэ гэдгийг бодоорой.

Тийм, Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хуулийг бол бид нар ч гэсэн хөнгөвчлөхийн төлөө байгаа. Та бүхэн ч гэсэн энэ дээр ажиллаж өгөөрэй. Тэгээд тал талаасаа хүчээ хавсраад, ер нь хөрөнгө оруулалт орох таатай нөхцөлийг л бүрдүүлэх ёстой. Тэгээд энэ ондоо багтаад бид нар Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хууль өргөн барина. Энэ хуулийг ч гэсэн парламент маань жоохон урагшаа харж баталж өгөөрэй. Энэ үед бол нэг тийм талцал, популизм гэлгүйгээр, явал хөрөнгө оруулалт татдаг улс болох вэ гэдэг бодлогыг бол хэдүүлээ батлах хэрэгтэй. Баярлалаа.

Ц.Даваасүрэн: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Хуулийн төсөлтэй холбогдуулаад үг хэлэх гишүүн байна уу? Алга байна.

Гишүүдийн асуугаад байгаа нь үнэн л дээ. Ер нь төсвийн зардал өндөр байх 2 талтай. Сайн ч талтай, муу ч талтай. Муу тал нь бол өр нэмэгдэх, алдагдал их байвал өр нэмэгдэх. Сайн тал нь юу гэж. Энэ төсвөөр дамжиж очиж байгаа, энэ төсвийн байгууллагад очиж байгаа мөнгө ч тэр, иргэнд очиж байгаа мөнгө ч тэр, цалингаар очиж байгаа мөнгө ч тэр эргээд яах вэ, худалдан авалт л хийгдэнэ шүү дээ. Бичгийн цаас авна, тоног төхөөрөмж авна, компьютер авна, талх авна, чихэр авна.

Тэгэхээр энэ төсвийн мөнгө гэдэг чинь эргээд худалдан авалт хийгээд байдаг, компаниудаас, бизнесийн салбараас. Бизнесийн салбар нь тэр орлого олсон мөнгөөрөө яах вэ, эргээд татвараар дахиад төсөвтөө л орж ирнэ шүү дээ. Ахиад л төсөвтөө эргээд л ороод ирнэ. Тэгэхээр энэ дээр нэг л аюул байдаг юм. Бид нар нөгөө импортын өргөн хэрэглээтэй улс учраас нэг компаниудын худалдан авалт сайжраад одоо ингээд борлуулалт нь өсөөд эхлэнгүүт, компаниудын мөнгө ихсэнгүүт яах вэ, нөгөө импортын бараа руугаа гүйдэг. Импортын бараа руугаа гүйнгүүт нөгөө валютын нөөцийг байхгүй болгочих гээд байдаг байхгүй юу. Тэгэхээр валютын нөөцийг сорохоор яах вэ. Валютын ханш өсдөг. Валютын ханш өсөхөөр юмны үнэ өсдөг. Ийм л зүйл байгаа юм. Тэгэхээр энэ сайн, муу 2-ын яг тэнцлийг хангасан ийм зарчмаар л бид явах ёстой. Түүнээс биш танаад байвал сайн ч зүйл биш. Танаад байх юм бол яах вэ, бизнесүүдийн борлуулалт муудаад л явчихна. Яагаад гэвэл хэрэглээний зах зээлийн 40 гаруй хувь нь төсвийн худалдан авалт байгаа. Төсвийн худалдан авалт буухаар яах вэ, компаниудын

борлуулалт буурна. Тэгээд үүний зохистой харьцааг хангах асуудал хамгийн чухал юм гэж.

Ингээд хуулийн төсөлтэй холбогдуулаад гишүүд үг хэлж дууслаа.

Одоо санал хураалт явуулна.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих нь зүйтэй гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалтад 16 гишүүн оролцож, 11 гишүүн дэмжиж, 68,8 хувиар энэ санал дэмжигдлээ.

Мөнхсоёл гишүүнийг дэмжсэнээр протоколд авъя.

Хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх асуудлын талаар Төсвийн байнгын хорооноос гаргах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Дамдинням Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулна.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төслийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай төслийг хэлэлцэх эсэх асуудлын талаарх хэлэлцүүлгийг Байнгын хороо хийж дууслаа.

13.16 цаг

Байнгын хорооны өнөөдрийн хуралдаан дууслаа.

Баярлалаа гишүүд ээ.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

П.ОЮУНГЭРЭЛ